



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2022 оны 01 сарын 25 өдөр

Дугаар А/05

Сайнцагаан сум

Ахмад настнуудад хүндэтгэл  
үзүүлэх тухай


Цагдаагийн албаны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4 дэх заалт, Монгол Улсын Ахмад настны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, Хэлтсийн даргын 2013 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн 18 дугаар тушаалаар батлагдсан "Ахмадын сангийн журам"-ын 3.2 дахь хэсэг, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/246 дугаар тушаалаар баталсан "Байгууллагын даргын тушаал гаргах /код-136/ журам"-ын 136.5.2-ын "г"-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Буян үйлдэгч хэмээх "Усан бар" жилийн сар шинийн баярыг угтаж ахмад настнуудыг хүлээн авч, хүндэтгэл үзүүлэх ахмад настны нэрсийг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

2. Ахмад настнуудад хүндэтгэл үзүүлэхэд шаардагдах 3.835.000 /гурван сая найман зуун гучин таван мянган/ төгрөгийг ахмадын сангийн данснаас гарган зарцуулахыг ахлах нягтлан бодогч /цагдаагийн ахмад Ц.Нарантогос/-д зөвшөөрсүгэй.

3. Тушаалыг бие бүрэлдэхүүнд танилцуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлагын тасгийн дарга /цагдаагийн дэд хурандаа Н.Өлзийжаргал/-д даалгасугай.

ДАРГА, ЦАГДААГИЙН  
ДЭД ХУРАНДАА



Б.МӨНХБАТ

